



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Зорчигч тээвэр гурав ОНӨААТҮГ-ын 2023 оны санхүүгийн тайланд хийсэн
аудитын тайлан

Аудитын код: НТАГ-2024/59/НА-СТА-ОНА

Цахим хуудас: www.audit.mn Улаанбаатар хот 2024 он	Гэрээгээр гүйцэтгэсэн: Мэдээлэл Аудит ХХК-ийн захирал: Д.Товуудорж Утас: 9904-9511 Цахим хаяг: medeelelaudit@gmail.com Аудитын менежер: А.Гэрэлмаа Утас: 9949-9667 Цахим хаяг: gerelmaa_634@yahoo.com Аудитор: Д.Туяа Утас: 8611-4488 Цахим хаяг: tuya88999@gmail.com Аудитор: Ц.Отгонкаргал Утас: 9100-8515 Цахим хаяг: medeelelaudit@gmail.com
---	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу

* АГУУЛГА

1. ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	3
2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН	5
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА	10
3.1 Компани /ОНӨААТҮГ, түүний үйл ажиллагаа	10
3.2 Компани /ОНӨААТҮГ-ын гадаад, дотоод орчин	10
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	11
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого ба толилуулгад орсон өөрчлөлт	11
3.5 Эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл	12
4. АУДИТЫН ТАЙЛАН	14
4.1 Ерөнхий зүйл	14
4.2 Материаллаг байдал	14
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	14
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	14
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	15
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	15
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	16
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ	18

Товчилсон үгийн жагсаалт

СТОУС	Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт
ОНӨААТҮГ	Орон нутгийн өмчит төрийн үйлдвэрийн газар
АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
ААНОАТ	Аж ахуй нэгжийн орлогын албан татвар
НБББББ	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг
НББОУС	Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт
СТА	Санхүүгийн тайлангийн аудит
ТБОНӨТХ	Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
НӨХГ	Нийслэлийн өмчийн харилцааны газар
НБББББ	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг
ЗДТГ	Засаг даргын тамгын газар



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
НИЙСЛЭЛ ДЭХ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

14200 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо,
Г.Амгын гудамж, Соёлын төв өргөө, Г.нэртэй, 8 давхар,
Утас: 7300 7734, Факс: (976-11) 22 01 34,
E-mail: oia@audit.gov.mn, Байцагч: www.aia90.mn

Баян, 03.15 № 546

тншай _____-ны № _____-т

АУДИТЫН ДҮГНЭЛТ

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, 8.4, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Зорчигч тээвэр гурав ОНӨААТҮГ-ын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Зорчигч тээвэр гурав ОНӨААТҮГ-ын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторовын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторовын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Байгууллагын удирдлага нь санхүүгийн тайлангаа бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг ашигласан байна. Цаашид тус байгууллагын талаар чиг үүрэг нь өөрчлөгдөж татан буугдах, нэгдэх асуудал гараагүй тул байгууллагын тасралтгүй байдлын талаар нөхцөл үүсээгүй гэж үзсэн болно.

Нийтийн тээврийн парк шинэчлэлтийн хүрээнд Нийслэлийн өмчийн харилцааны газраас 100 ширхэг их багтаамжийн дизель хөдөлгүүртэй XML6105J15C загварын автоусыг хүлээн авсан бөгөөд үүнтэй холбоотойгоор гаралтыг 62 хувиар нэмэгдүүлж нийтийн тээврийн 20 чиглэлд нийт 120 гаралттайгаар ажилласан байна.

Аудитын гол асуудал

Аудитыг гүйцэтгэхэд аудитын хамрах хүрээний хязгаарлалт хийх шаардлагагүй болон хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй нөхцөл үүсээгүй тул бидний олж авсан нотолгоо нь аудитын дүгнэлтийн суурь болоход хүрэлцээтэй, зохистой гэж үзлээ.

Тус байгууллагын зорилтот түвшний төлөвлөгөөг Нийслэлийн Засаг даргын 2023 оны 09 дүгээр сарын 22-ны өдрийн "Захирамжийн хавсралтад өөрчлөлт

оруулах тухай" А/1125 дугаар захирамжаар нийт орлогыг 23,721,476.3 мянган төгрөг, нийт зардлыг 31,307,394.84 мянган төгрөг, алдагдлыг 7,585,918.5 мянган төгрөг, борлуулалтын орлогын нэг төгрөгт ногдох зардлыг 1.3 төгрөгөөр баталсан байна.

Бусад асуудлын хэсэг

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 5 бүлэг 56 зорилт арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 94.5 хувийн гүйцэтгэлтэй гэж тайлагнасан байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй ба үүнд ямар нэг төрлийн баталгаажуулах дүгнэлт гаргаагүй болно.

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР



М.ЭРДЭНЭЖАРГАЛ

ЗАУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН**2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан**

2023 оны 12 дугаар сарын 31-нээр дуусвар болсон

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Тзүүлэлт	2022 оны 12-р сарын 31	2023 оны 12-р сарын 31
1.1.1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	216,887,310.53	504,147,986.88
1.1.2	Дансны авлага	162,187,908.75	201,720,039.85
1.1.4	Бусад авлага	-	9,006,666.30
1.1.6	Бэрээ материал	1,161,838,689.87	1,565,260,079.49
1.1.7	Урьдчилж төлсөн зардал/тооцро	95,806,289.00	97,296,221.93
	Эргэлтийн хөрөнгийн дүн	1,636,320,198.15	2,377,430,994.45
1.2	Эргэлтийн бус хөрөнгө		
1.2.1	Үндсэн хөрөнгө	24,497,005,849.70	45,670,000,596.76
1.2.2	Биет бус хөрөнгө	275,626,700.00	275,626,700.00
1.2.8	Бусад эргэлтийн бус хөрөнгө	-	-
	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	24,772,632,549.70	45,945,627,296.76
1.3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	26,408,952,747.85	48,323,058,293.21
2	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ		
2.1	Өр төлбөр		
2.1.1	Богино хугацаат өр төлбөр		
2.1.1.1	Дансны өглөг	940,382,601.52	667,560,343.55
2.1.1.2	Цалингийн өглөг	-	-
2.1.1.3	Тэтгэврийн өр	832,140,764.14	419,781,065.39
2.1.1.4	НДШ-ийн өглөг	1,670,646,793.98	168,705,282.42
2.1.1.6	Хүүний өглөг	61,504,483.55	26,144,480.02
2.1.1.7	Нэгдэл ашгийн өглөг	0.00	302,197,750.00
2.1.1.8	Урьдчилж орсон орлого	14,370,244,373.15	43,314,614,926.71
2.1.1.9	Нөөц /өр төлбөр/	-	-
2.1.1.10	Бусад богино хугацаат өр төлбөр	2,547,966.21	4,482,173,579.24
	Богино хугацаат өр төлбөрийн дүн	17,877,466,982.55	49,470,177,427.33
2.1.2	Урт хугацаат өр төлбөр		
2.1.2.4	Бусад урт хугацаат өр төлбөр	17,336,521,296.05	6,145,526,028.90
	Урт хугацаат өр төлбөрийн дүн	17,336,521,296.05	6,145,526,028.90
2.2	Өр төлбөрийн нийт дүн	35,213,988,278.60	55,608,787,768.88
2.3	Эздийн өмч		
2.3.1	Өмч-төрийн	2,065,596,348.11	2,065,596,348.11
2.3.2	- хувийн	-	-
2.3.6	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	287,248,984.38	287,248,984.38
2.3.7	Гадаад валютын хөрвүүлэлтийн нөөц	-	-
2.3.8	Эздийн өмчийн бусад хэсэг	275,626,700.00	275,626,700.00
2.3.9	Хуримтлагдсан ашиг	(11,433,507,563.24)	(9,921,117,195.51)
2.3.11	Эздийн өмчийн дүн	(8,805,035,530.75)	(7,292,645,163.02)
2.4	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	26,408,952,747.85	48,323,058,293.21

2.2 Аудит хийсэн дэлгэрэнгүй орлогын тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-нээр дуусвар болсон

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2022 оны 12-р сарын 31	2023 оны 12-р сарын 31
1	Борлуулалтын орлого (цэвэр)	13,974,254,014.70	24,380,064,568.10
2	Борлуулалтын өртөг	15,162,887,831.76	25,461,679,768.49
3	Нийт ашиг(алдагдал)	(1,188,433,817.06)	(1,081,615,190.39)
5	Хүүгийн орлого	0.00	65,376.43
8	Бусад орлого	7,033,457,306.99	6,235,170,818.39
10	Ерөнхий ба удирдлагын зардал	2,004,890,776.33	1,865,415,824.91
11	Санхүүгийн зардал	1,749,777,989.00	943,041,876.18
12	Бусад зардал	267,614,362.51	93,375,174.79
13	Гадаад валютын хэмшийн зөрүүний олз (гарз)	(8,244,685.69)	3,209.66
14	Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	(14,503,123.84)	0.00
18	Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	1,800,192,552.56	2,251,791,338.21
19	Орлогын татварын зардал	219,726,427.63	247,203,220.48
20	Татварын дараах ашиг (алдагдал)	1,580,466,124.93	2,004,588,117.73
21	Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг (алдагдал)		
22	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	1,580,466,124.93	2,004,588,117.73
23	Бусад дэлгэрэнгүй орлого		
23.1	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдлийн зөрүү		
23.2	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү		
23.3	Бусад олз (гарз)		
24	Орлогын нийт дүн	1,580,466,124.93	2,004,588,117.73
25	Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг (алдагдал)		

2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-нээр дуусвар болсон

/төгсгөлөөр/

№	ҮЗҮҮЛЭЛТ	Өмч	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Эздэйн өмчийн бусад хэсэг	Хуриятлагдсан ашиг	Нийт дүн
1	2021 оны 12 -р сарын 31-ний үлдэгдэл	2,065,596,348.11	292,516,831.66	275,626,700.00	(13,026,618,544.82)	(10,382,879,265.05)
2	Нийтлэн бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	-	-	-	12,645,256.65	12,645,256.65
3	Залруулсан үлдэгдэл	2,065,596,348.11	292,516,831.66	275,626,700.00	(13,013,973,288.17)	(10,380,234,008.40)
4	Тайлант үеийн цөөр шилжилд(адагдэл)	-	-	-	1,500,466,124.03	1,500,466,124.03
5	Бусад дэлгэрэнгүй орлого	-	-	-	-	-
6	Өмчид гарсан өөрчлөлт	-	-	-	-	-
7	Зарласан ногдол ашиг	-	-	-	-	-
8	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн	-	(5,267,847.28)	-	-	(5,267,847.28)
9	2022 оны 12 -р сарын 31-ний үлдэгдэл	2,065,596,348.11	287,248,984.38	275,626,700.00	(11,433,507,563.24)	(8,805,035,530.75)
10	Нийтлэн бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	-	-	-	-	-
11	Залруулсан үлдэгдэл	2,065,596,348.11	287,248,984.38	275,626,700.00	(11,433,507,563.24)	(8,805,035,530.75)
12	Тайлант үеийн цөөр ашиг (адагдэл)	-	-	-	2,004,588,117.73	2,004,588,117.73
13	Бусад дэлгэрэнгүй орлого	-	-	-	-	-
14	Өмчид гарсан өөрчлөлт	-	-	-	-	-
15	Зарласан ногдол ашиг	-	-	-	(492,197,750.00)	(492,197,750.00)
16	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн	-	-	-	-	-
17	2023 оны 12 -р сарын 31-ний үлдэгдэл	2,065,596,348.11	287,248,984.38	275,626,700.00	(9,921,117,165.81)	(7,292,645,163.02)

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-нээр дууссаар болсон

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	ҮЗҮҮЛЭЛТ	2022 оны 12-р сарын 31	2023 оны 12-р сарын 31
1	Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
1.1	Мөнгөн орлогын дүн (+)	29,665,117,010.15	26,292,101,892.84
1.1.1	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	2,061,352,575.12	2,748,315,912.30
1.1.2	Эрхийн шалтгал, хураамж, төлбөрийн орлого	-	11,614,260.00
1.1.3	Даатгалын нөхцөөрөөс хүлээн авсан мөнгө	48,342,865.80	90,955,338.96
1.1.4	Буцаан авсан албан татаар	-	920,672.00
1.1.5	Татаас, санхүүжилтийн орлого	18,553,402,561.50	21,508,581,668.00
1.1.6	Бусад мөнгөн орлого	9,002,018,985.73	1,531,713,841.56
1.2	Мөнгөн зарлагын дүн (-)	17,433,888,368.84	26,783,806,661.71
1.2.1	Ажиллагчдад төлсөн	4,088,665,991.43	7,697,049,029.59
1.2.2	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	2,049,572,532.57	3,302,258,391.88
1.2.3	Бараа материал худалдан авахад төлсөн	563,107,984.00	604,284,358.10
1.2.4	Ашиглалтын зардалд төлсөн	1,272,613,094.96	1,332,737,759.09
1.2.5	Түлш шатахуун, тээврийн хөлс, салбарт хэрэгсэлд төлсөн	6,313,649,454.10	10,628,579,346.72
1.2.6	Хуулийн төлбөрт төлсөн	1,799,951,760.82	976,955,851.64
1.2.7	Татаарын байгууллагад төлсөн	683,734,553.81	1,281,269,676.13
1.2.8	Даатгалын төлбөрт төлсөн	110,175,090.00	307,080,438.82
1.2.9	Бусад мөнгөн зарлага	552,417,907.15	663,300,799.74
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	12,231,228,641.31	(491,403,758.87)
2	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
2.1	Мөнгөн орлогын дүн (+)		
2.1.1	Үндсэн хөрөнгө борлуулсны орлого	-	-
2.1.2	Биет бус хөрөнгө борлуулсны орлого	-	-
2.1.3	Хөрөнгө оруулалт борлуулсны орлого	-	-
2.1.4	Бусад урт хугацаат хөрөнгө борлуулсны орлого	-	-
2.1.7	Хүлээн авсан ногдол ашиг	-	-
2.2	Мөнгөн зарлагын дүн (-)	6,211,658,610.57	78,076,214.00
2.2.1	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	6,211,658,610.57	78,076,214.00
2.2.2	Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	-	-
2.2.3	Хөрөнгө оруулалт олж эзэмшихэд төлсөн	-	-
2.2.4	Бусад урт хугацаат хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	-	-
2.2.5	Бусдад олгосон зээл болон урьдчилгаа	-	-
2.3	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(6,211,658,610.57)	(78,076,214.00)
3	Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
3.1	Мөнгөн орлогын дүн (+)	3,759,729,239.64	7,671,534,600.00
3.1.1	Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	3,759,729,239.64	7,671,534,600.00
3.1.2	Хувьцаа болон өмчийн бусад үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	-	-
3.1.3	Төрөл бүрийн хандиа	-	-
3.2	Мөнгөн зарлагын дүн (-)	9,808,004,733.79	6,814,597,160.44
3.2.1	Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн мөнгө	9,808,004,733.79	6,714,597,160.44
3.2.2	Санхүүгийн түрээсийн өглөлт төлсөн	9,808,004,733.79	6,714,597,160.44
3.2.3	Хувьцаа буцаан худалдан авахад төлсөн	-	-
3.2.4	Төлсөн ногдол ашиг	-	100,000,000.00
3.3	Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(6,048,275,494.15)	856,937,439.56
4	Валютын ханшийн зөрүү	28,084.27	3,209.66
5	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	(29,677,379.14)	287,460,676.35
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	246,364,689.67	216,687,310.53
7	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	216,687,310.53	504,147,986.88

2.5 Аудит хийсэн эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

/млн.төгрөг/

Д/д	Үзүүлэлт	2023 оны төлөвлөгөө	2023 оны гүйцэтгэл	Зөрүү	Хувь
	1. Нийт орлого	23,721,476.3	30,615,304.5	8,893,828.1	129.1
1.1	Шугамын орлого	5,185,895.3	2,778,306.0	(2,407,587.3)	53.6
1.2	Санхүүжилтийн орлого Зардлын зөрүү	14,632,043.9	19,128,460.2	4,496,416.3	130.7
1.3	Нөхөн олговор – хөнгөлөлттэй зорилгид	3,111,537.2	2,158,777.9	(952,759.2)	69.4
1.4	Сургуулийн автобусны орлого	720,000.0	280,241.3	(439,758.7)	36.1
1.5	Үйл ажиллагааны бусад орлого	72,000.0	335,235.5	263,235.5	465.6
1.6	Хөрөнгө оруулалтын орлого /ц автобус/	0.0	5,954,281.4	5,954,281.4	
	2. Нийт зардал	31,307,394.8	28,355,829.1	(2,951,565.8)	90.6
2.1	Цалин	8,205,148.8	7,582,162.7	(622,986.1)	92.4
2.2	НДШ	1,107,695.1	1,007,610.5	(100,084.6)	91.0
2.3	Шатахуун	8,558,242.0	8,514,965.8	(43,276.2)	99.5
2.4	Тосолгооны материал	1,419,164.6	382,483.4	(1,036,681.3)	27.0
2.5	Сэлбэг хэрэгсэл	1,450,000.0	1,184,460.6	(265,539.4)	81.7
2.6	Дугуйн зардал	232,285.7	122,537.4	(109,748.3)	52.8
2.7	Хөдөлмөр хамгаалал	216,570.2	140,296.9	(76,273.3)	64.8
2.8	Үндсэн хөрөнгийн элэгдэл	6,086,864.8	6,179,095.4	92,230.6	101.5
2.9	Бичиг хэрэглэл	48,514.6	33,925.2	(14,589.4)	69.9
2.10	Хангамжийн зардал	73,832.5	55,907.1	(17,925.4)	75.7
2.11	Ариун цэврийн зардал	67,898.2	55,486.5	(12,411.7)	81.7
2.12	Засвар үйлчилгээ	48,300.0	15,794.8	(32,505.2)	32.7
2.13	Цахилгаан	917,436.2	742,392.5	(175,043.7)	80.9
2.14	Ус /Бохир соруулах/	30,000.0	18,200.0	(11,800.0)	60.7
2.15	Халаалт дулаан	22,500.0	17,352.9	(5,147.1)	77.1
2.16	Харилцаа холбоо	16,304.0	9,416.3	(6,887.7)	57.8
2.18	Газрын төлбөр	2,094.2	2,402.7	308.5	114.7
2.19	Тээврийн хэрэгслийн татаар	24,016.8	22,690.0	(1,326.8)	94.5
2.20	Даятгалын үйлчилгээ	311,555.0	298,125.2	(13,429.8)	95.7
2.21	Сургалт, сурталчилгаа	32,700.0	27,543.0	(5,157.0)	84.2
2.22	Албан томилолт	20,000.0	6,511.6	(13,488.4)	32.6
2.23	Тэтгэвэрийн тэтгэмж буцалтгүй тусламж	344,889.6	120,812.4	(224,077.2)	35.0
2.24	Гадны үйлчилгээ	216,590.0	177,862.8	(38,727.2)	82.1
2.25	Үйл ажиллагааны бусад	123,247.0	93,585.8	(29,661.2)	75.9
2.26	Түрээсийн зардал	768,000.0	608,850.0	(159,150.0)	79.3
2.27	Зээлийн хүү /Цахилгаан автобус/	963,545.4	943,041.9	(20,503.5)	97.3
	3. Ашиг, алдагдал	(7,585,918.5)	2,251,791.3	9,837,709.8	
	Орлогын нэг төгрөгт ногдох зардал	1.32	0.95	0.37	

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Компани /ОНӨААТҮГ, түүний үйл ажиллагаа

Тус байгууллага нь Нийслэлийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын тэргүүлэгчдийн 2018 оны 73 дугаар тогтоолоор Зорчигч тээвэр нэгтгэл ОНӨААТҮГ-аас салж, Зорчигч тээвэр гурав ОНӨААТҮГ болж үйл ажиллагаагаа явуулж байна. Байгууллагын улсын бүртгэлийн гэрчилгээнд Орон нутгийн өмчит ААТҮГ гэсэн статустай байна. Өмчийн 100 хувийг Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн хурал эзэмшиж байна.

Зорчигч тээвэр гурав ОНӨААТҮГ-ын эрхэм зорилгыг "Зорчигч тээврийн үйлчилгээг орчин үеийн түвшинд хүргэж хөгжүүлэх, чанар үр дүнг дээшлүүлэх, нийслэлийн иргэд зорчигчидоо шуурхай, боловсон, ая тухтай үйлчилгээ үзүүлэх, хөрөнгө оруулалтын үр дүнг дээшлүүлэх, үйлчилгээний менежментийг сайжруулах, төсөл хэрэгжүүлэх, хэтийн төлөвийг тодорхойлох замаар Улаанбаатар хотын тээврийн үйлчилгээг бэлхийн жишээт хүргэхэд оршино" гэж тодорхойлжээ.

Зорчигч тээвэр гурав ОНӨААТҮГ-ын дүрэмд тус байгууллагын үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Нийслэлийн иргэдэд нийтийн зорчигч тээврийн үйлчилгээг тав тухтай, аюулгүй байдлыг хангасан тээврийн хэрэгслээр хүргэх;
- Нийтийн зорчигч тээврийн хэрэгслүүдэд хийх их болон урсгал засварын нэгдсэн төлөвлөгөө гарган хэрэгжүүлэх, ашиглалтад хяналт тавих;
- Нийтийн зорчигч тээврийн үйл ажиллагаа явуулахад шаардагдах боловсон хүчнийг бэлтгэх, мэргэжил боловсролыг дээшлүүлэх чиглэлээр сургалтын үйл ажиллагаа явуулах;
- Нийтийн тээвэрт орчин үеийн дэвшилтэт техник, технологийг нэвтрүүлэх, шинээр автобус, троллейбус угсрах, үйлдвэрлэх, дүүргүүдийн гэрэлтүүлгийн засвар, ашиглалтын ажлыг удирдан, зохион байгуулж гүйцэтгэх гэсэн байна.

Зорчигч тээвэр гурав ОНӨААТҮГ нь 2023 онд Монгол Улсын Засгийн газар болон Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Нийслэлийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлд тусгагдсан зорилтуудыг хэрэгжүүлэхэд үйл ажиллагаагаа чиглүүлэн, нийтийн тээврийн үйлчилгээнд орчин үеийн шинэ дэвшилтэт технологийг нэвтрүүлэн, үйлчилгээний чанар хүртээмж, үр дүнг дээшлүүлж, нийслэлийн хөгжил, бүтээн байгуулалтад хувь нэмэр оруулах, нийтийн тээвэрээр шуурхай боловсон, ая тухтай үйлчилгээг иргэдэд хүргэх зорилттой ажилсан байна.

3.2 Компани /ОНӨААТҮГ-ын гадаад, дотоод орчин

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлтүүд орсон байна. Үүнд:

- "Төрийн хэмнэлтийн тухай хууль"-д нэмэлт өөрчлөлт орсон.
- "Нийгмийн даатгалын ерөнхий хууль"-д нэмэлт өөрчлөлт орсон.
- Нийслэлийн нийтийн тээврийн газрын даргын 2023 оны А/42 дугаар тушаалаар "Удирдлага, мэдээллийн болон цахим төлбөрийн системээр нийтийн тээврийн үйлчилгээний ажлын гүйцэтгэлийг тооцох журам"
- Нийслэлийн "Зорчигч тээвэр гурав" ОНӨААТҮГ-ын даргын 2023 он 03 дугаар сарын 21-ний өдрийн А/31 дугаар тушаал "Түлшний норм шинэчлэн тогтоох тухай"
- Нийслэлийн "Зорчигч тээвэр гурав" ОНӨААТҮГ-ын даргын 2023 он 05 дугаар сарын 17-ны өдрийн А/42 дугаар тушаал "Нэмэгдэл цалин олгох тухай"
- Нийслэлийн "Зорчигч тээвэр гурав" ОНӨААТҮГ-ын даргын 2023 он 07 дугаар сарын 26-ны өдрийн А/52 дугаар тушаал "Бэлтгэл жолоочийн цагийн хөлс батлах тухай"
- Нийслэлийн "Зорчигч тээвэр гурав" ОНӨААТҮГ-ын даргын 2023 он 10 дугаар сарын 26-ны өдрийн А/65 дугаар тушаал "Цалин хөлсний журамд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай"

Компанийн удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Дотоод хяналтын хэлтэс нь Зорчигч тээвэр гурав ОНӨААТҮГ-ын даргын баталсан удирдамжийн дагуу Санхүү бүртгэлийн хэлтсийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийж зөвлөмж хүргүүлэн ажилласан байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудиторос шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

Удирдах зөвлөл нь нийт 5 гишүүнтэйгээр үйл ажиллагаагаа явуулж байна. Удирдах зөвлөлийн хурлыг 2023 онд 3 удаа зохион байгуулж, байгууллагын үйл ажиллагааны тайлан, үйлдвэрийн газрын 2024 оны эдийн засгийн үр ашгийг дээшлүүлэх зорилт болон худалдан авах ажиллагааны төлөвлөгөө зэргийг хэлэлцэж, Төхилтын цогцолбор барилгын төсвийн асуудлыг шийдвэрлэж гураван тогтоолоор баталгаажуулсан байна. Удирдах Зөвлөл нь Нийслэлийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2014 оны 54 дүгээр тогтоолоор батлагдсан "Нийслэлийн өмчийн хуулийн этгээдийн удирдах зөвлөлийн ажиллах журам"-ын дагуу ажилласан байна.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Зорчигч тээвэр гурав ОНӨААТҮГ-ын 2023 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг ажруул сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв тогилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Зорчигч тээвэр гурав ОНӨААТҮГ-ын мөрдөн ажиллаж буй НБББББ-т холбогдох хууль тогтоомжийн шинэчлэлийг хийгээгүй байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого ба тогилуулгад орсон өөрчлөлт

Зорчигч тээвэр гурав ОНӨААТҮГ-ын 2023 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2017 оны 361 дүгээр тушаалаар баталсан аж ахуйн нэгжид мөрдөгдөх "Санхүүгийн тайлан, тодруулгыг бэлтгэх заавар"-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 21,914,105.5 мянган төгрөгөөр буюу 82.9 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	/мянган төгрөгөөр/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	216,687.3	504,148.0	287,460.7
Аалага	162,187.9	210,728.7	48,538.8
Бариа материал	1,161,636.7	1,565,260.1	403,621.4
Үрөдчилгаа	95,806.3	97,296.2	1,489.9
Үндсэн хөрөнгө	24,497,005.8	45,670,000.6	21,172,994.7
Биет бус хөрөнгө	275,626.7	275,626.7	-
Нийт хөрөнгийн дүн	26,408,952.7	48,323,058.3	21,914,105.5
Өр төлбөр	35,213,988.3	55,615,703.5	20,401,715.2
Эздийн өмч	- 8,605,035.5	- 7,292,645.2	1,512,390.4
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	26,408,952.7	48,323,058.3	21,914,105.5

Өмнөх оны үзүүлэлтээс мөнгөн хөрөнгө, авлага, бараа материал, үндсэн хөрөнгө, өр төлбөр, эздийн өмчийн данснуудад материаллаг дүнгээр өөрчлөлт гарсан байна. Үүнд:

Мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл 504,148.0 мянган төгрөг болж 287,460.7 мянган төгрөгөөр өссөн нь 2023 оны 12 дугаар сарын машин цагийг хүлээгдэж буй гүйцэтгэлээр тооцож Нийслэлийн нийтийн тээврийн газраас үнэ төлбөргүй зорчигчийн нөхөн олговрын орлого, зардлын зөрүү санхүүжилтийн орлогыг 2023 ондоо багтаан хуваарилж дансанд орж ирснээс шалтгаалан мөнгөн хөрөнгийн үлдэгдэл нэмэгдсэн байна.

Авлага дансны үлдэгдэл 210,726.7 мянган төгрөг болж 48,538.8 мянган төгрөгөөр өссөн нь Нийтийн тээврийн үйлчилгээний газрын зардлын зөрүү санхүүжилтийн авлага 61,172.4 мянган төгрөг, Улаанбаатар смарт карт ХХК-иас авах шугамын үйлчилгээний орлого 34,735.8 мянган төгрөг болон замд яваа мөнгө 9,006.7 мянган төгрөг, ажилчидтай холбоотой авлага 51,635.9 мянган төгрөгийн авлагуудтай холбоотой байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 1,565,260.1 мянган төгрөг болж өмнөх оноос 403,621.4 мянган төгрөгөөр өссөн нь цахилгаан автобусны баталгаат засварын төлөөлөгөөт ажил хийхтэй холбоотой сэлбэгийг нөөцлөн авснаас шалтгаалсан бөгөөд бусад материалын хувьд зайлшгүй нөөц бүрдүүлэх агуулахын үлдэгдлийн тоо хэмжээ нэмэгдээгүй байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 45,670,000.6 мянган төгрөг болж 21,172,994.7 мянган төгрөгөөр өссөн нь нийслэлийн нийтийн тээврийн парк шинэчлэлийн хүрээнд Нийслэлийн Засаг даргын 2023 оны А/881 дүгээр захирамжаар улсын төсвийн хөрөнгө оруулалтаар нийлүүлэгдсэн их багтаамжийн дизел хөдөлгүүртэй Xiamen XML6105J15C маркийн 100 ширхэг автобусыг 27,274,013.9 мянган төгрөг, Нийслэлийн Засаг даргын 2022 оны А/61 дүгээр захирамж, 2023 оны А/336 дугаар захирамж, НӨХГ-ын даргын А/90 дүгээр тушаал, Зорчигч тээвэр гурав ОНӨААТҮГ-ын даргын 2023 оны 05 дугаар сарын 25-ны өдрийн Б/43 дугаар тушаалыг тус тус үндэслэн 6,730,045.3 мянган төгрөгийн үнэ бүхий 45 ширхэг тээврийн хэрэгслийг данс бүртгэлээс хассан. НӨХГ-ын А/569 тушаалаар үйлдвэрийн газрын эргэлтийн бус хөрөнгийн дансанд бүртгэлтэй элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн, ашиглах боломжгүй болсон 180 ширхэг 155,560.0 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, тавилга эд хогшил, компьютер дагалдах хэрэгсэлийг данс бүртгэлээс хасаж аялсан, тайлант хугацаанд 6,132,507.9 мянган төгрөгийн элэгдэл байгуулсан зэрэг нь үндсэн хөрөнгийн өөрчлөлтөд нөлөөлжээ.

Өр төлбөр дансны үлдэгдэл 55,615,703.5 мянган төгрөг болж 20,401,715.2 мянган төгрөгөөр өссөн нь Нийслэлийн Засаг даргын 2023 оны А/881 дүгээр захирамжаар улсын төсвийн хөрөнгө оруулалтаар нийлүүлэгдсэн их багтаамжийн дизел хөдөлгүүртэй Xiamen XML6105J15C маркийн 100 автобусыг 27,274,013.9 мянган төгрөг болон Нийслэлийн Засаг даргын 2023 оны А/90 дүгээр захирамжаар 7,671,534.6 мянган төгрөгийн цахилгаан автобусны санхүүжилт орж ирсэн, эхний үлдэгдэлээс 5,954,281.2 мянган төгрөгийг хөрөнгө оруулалтын орлогоор хүлээн зөвшөөрч бүртгэсэн зэргээс шалтгаалжээ.

Эздийн өмч 7,292,645.2 мянган төгрөг болж 1,512,390.4 мянган төгрөгөөр нэмэгдсэн Нийслэлийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2023 оны 07 дугаар сарын 03-ны өдрийн 90 дүгээр тогтоолоор 2022 оны 492,197.7 мянган төгрөгийн ногдол ашиг зарласан болон тайлант хугацаанд 2,004,588.1 мянган төгрөгийн цэвэр ашигтай ажилласан зэргээс шалтгаалжээ.

3.5 Эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 3, 20 дугаар зүйлийн 20.1.3-д заасны дагуу Зорчигч тээвэр гурав ОНӨААТҮГ-ын захирал нь байгууллагын үйл ажиллагаа, санхүүгийн төлөвлөгөө боловсруулж, зохих байгууллагаар батлуулж, биелэлтийг хангах үүрэгтэй.

Нийслэлийн Засаг даргын 2023 оны 09 дүгээр сарын 22-ны өдрийн А/1125 дугаар захирамжаар Эдийн засаг, санхүүгийн үр ашгийг дээшлүүлэх зорилтыг баталсан байна.

Тайлант онд нийт орлогыг 23,721,476.3 мянган төгрөг, нийт зардлыг 31,307,394.8 мянган төгрөг, алдагдлыг 7,585,918.5 мянган төгрөг, борлуулалтын орлогын нэг төгрөгт ногдох зардал 1.32 төгрөг, тухайн жилийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг 1,095,200.0 мянган төгрөгийн зардалтай ажиллахаар баталсан байна.

Гүйцэтгэлээр 30,615,304.5 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, 28,355,829.1 мянган төгрөгийн зардал гарган, 2,259,475.4 мянган төгрөгийн ашигтай ажилласан байна. Орлогын эх үүсвэр нь 21,287,238.2 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс олгосон татаас, 5,954,281.4 мянган төгрөгийн хөрөнгө оруулалтын орлого, 3,373,784.9 мянган төгрөгийн үндсэн болон туслах үйл ажиллагааны орлогоос бүрджээ.

Нийт орлогын гүйцэтгэл 23,721,476.3 мянган төгрөг болж төлөвлөснөөс 6,893,828.1 мянган төгрөг буюу 129.1 хувиар давуулан биелүүлсэн нь шугамын орлого нь нийтийн тээврийн хүн урсгалыг нэмэгдүүлэх картаар зорчих зорчилтыг нэмэгдүүлэх зорилгоор шугамын орлогыг өндөр төлөвлөсөн боловч "Ситибаз консалтинг" ХХК-ийг татан буулгасантай холбогдуулан зорчигчдод хяналт тавих ажилтан багасаж үүнтэй холбоотой нийтийн тээврийн үйлчилгээ үзүүлдэг байгууллагуудын шугамын орлогын түвшин буурч төлөвлөгөө 2,407,587.3 мянган төгрөгөөр тасарсан хэдий ч зардлын зөрүү санхүүжилтын орлого нь 4,496,429.3 мянган төгрөгөөр өссөн нь Шинээр 100 ширхэг евро-5 хөдөлгүүртэй БНХАУ-д үйлвэрлэсэн Xiamen XML6105J15C загварын автобус авсантай холбогдуулан гаралт нэмэгдсэнээс орлого өсөх шалтгаан болсон байна.

Нийт зардлын гүйцэтгэл 28,363,513.2 мянган төгрөг болж, төлөвлөснөөс 2,943,881.7 мянган төгрөг буюу 90.6 хувийн гүйцэтгэлтэй байна. Тайлант жилд нийт гарсан зардал 9.4 хувиар буюу 2,943,881.7 төгрөгөөр хэмнэгдсэн. Нийт төлөвлөсөн 26 зардлаас 23 төрлийн зардал хэмнэгдэж, 2 төрлийн зардал хэтэрч, 10 хүртэл хувийн хэмнэлттэй 6 зардал, 10-аас дээш хувийн хэмнэлттэй 18 төрлийн зардал гарсан байна.

Тайлант онд 30,615,304.5 мянган төгрөгийн орлоготой 28,363,513.2 мянган төгрөгийн зардалтай 2,004,588.1 мянган төгрөгийн цэвэр ашигтай ажилласан байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д "Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана." гэж заасны дагуу Зорчигч тээвэр гурав ОНӨААТҮГ-ын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланд хийсэн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх ОНӨААТҮГ, түүний орчин, аудитад хамзаралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Мөн байгууллагын санхүүгийн үйл ажиллагааг сайжруулах, нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг холбогдох хууль, журмын дагуу боловсруулан мөрдөх, дотоод хяналтыг сайжруулахтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Мэдээлэл-Аудит ХХК-ийн ахлах аудитор Н.Ганданбаавар, ахлах аудитор Д.Түяа, аудитор Ц.Отгонжаргал нар гүйцэтгэж чанарын хяналтын менежер А.Гэрэлмаа, захирал Д.Товуудорж нар анхан шатны чанарын хяналтыг, Санхүү-нийцлийн аудитын хэлтсийн аудитын менежер Д.Отгонбаяр, хэлтсийн дарга Х.Түвшинбаяр, газрын дарга, тэргүүлэх аудитор М.Эрдэнэжаргал нар дараагийн шатны чанарын хяналтыг тус тус хэрэгжүүлсэн.

Зорчигч тээвэр гурав ОНӨААТҮГ-ын 2023 оны санхүүгийн тайланг Мэдээлэл-Аудит ХХК-д 2024 оны 02 дугаар сарын 19-ний өдрийн 131 дүгээр албан бичгээр ирүүлсэн.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2022 оны орлогын дэлгэрэнгүй тайлангийн нийт зардлаар сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл "дүнд" гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1.5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2022 оны санхүүгийн орлогын дэлгэрэнгүй тайлангийн нийт зардлын 19,427,245.2 мянган төгрөгөөс 1.5 хувиар буюу 291,408.7 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75.0 хувь буюу 218,556.5 мянган төгрөгөөр тогтоосноо.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор жирэмсний амралт болон тэтгэвэрт гарсан ажилчдын орон тоонд нөхөн авахгүйгээр орлуулан ажиллуулж цалингийн зардлаас 19,179.1 мянган төгрөг, нийгмийн даатгалын зардлаас 2,589.2 мянган төгрөг шагнал урамшуулал болон тусламжийн зардлаас 224,077.2 мянган төгрөг, сургалт болон өдөр тутмын үйл ажиллагаанд хэрэглэгддэг цаясны хэрэгтээг багасгах зорилгоор мэдээ мэдээллүүдийг цахим байдлаар шийдэж 14,589.4 мянган төгрөгийн бодит хэмнэлтийг тус тус гаргасан байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг НТАГ-2024/59/НА-СТА-ОНА

тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст тайлант хугацаанд цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий нийт оруулбал зохих 149 мэдээллээс 5 мэдээлэл буюу 1,241,525.4 мянган төгрөгийн мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байгаа нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3 "Тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх" гэсэн заалттай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны хуулийн хэрэгжилтийг хангуулж ажиллах, зөрчлийг давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлсэн.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хуулийн холбогдох заалттай нийцээгүй гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Завсрын аудитаар хэрэгжүүлсэн горим сорилын үр дүнд нийт 5,222,913.3 мянган төгрөгийн асуудлыг илрүүлж, асуудлын бүртгэлээр зөвлөмж өгсөн ба жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудитаар дахин хянахад 4,344,518.8 мянган төгрөгийн алдааг залруулж, зөрчлийг арилгасан байна. Биелэгдээгүй 878,394.5 мянган төгрөгийн 4 алдаа, зөрчлийг аудитын илрүүлэлт хэсэгт тусгасан болно.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх аудитаар зөрчлийг арилгах 27,389.2 мянган төгрөгийн 1 албан шаардлага, 304,256.5 мянган төгрөгийн 5 зөвлөмж өгснийг хянахад хэрэгжилт 78.0 хувийн биелэлттэй байна.

Хүснэгт 2 Албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Д/д	Үзүүлэлт	Өмнөх аудитаар өгсөн		Биелэлт		
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
5	1	2	3	4	5	6
1	Албан шаардлага	1	27,389.2	1	19,172.4	70%
2	Зөвлөмж	5	304,256.5	5	261,660.6	86%
	Нийт дүн	6	331,645.7	6	280,833.0	78%

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Нийслэлийн Засаг даргын 2022 оны А/378 дугаар захирамжийн дагуу Улаанбаатар хотын Сонгинохайрхан дүүргийн 22 дугаар хороонд "Зорчигч тээвэр гурав ОНӨААТҮГ нийтийн тээврийн автобус парк" төслийн хүрээнд барьж буй барилга угралтын ажлын гүйцэтгэлийн талаарх мэдээллийг дараагийн аудитаар авч үзэх нь зүйтэй гэж үзлээ.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 5,360,824.9 мянган төгрөгийн 4 алдаа¹ илэрснийг аудитын явцад залруулсан. Үүнд:

- Санхүүгийн байдлын тайланд урт хугацаат өр төлбөрөөс 4,476,398.1 мянган төгрөгийг богино хугацаат өр төлбөр дансанд шилжүүлж бүртгээгүй.
- Санхүүгийн байдлын тайланд Нийслэлийн Засаг даргын тамгын газарт өгөх 392,197.8 мянган төгрөгийн ногдол ашгийн өглөгийг дансны өглөг дансанд ангилал буруу тайлагнасан.
- Өмчийн өөрчлөлтийн тайланд Нийслэлийн Засаг даргын тамгын газарт өгөх 2022 оны ногдол ашиг 492,197.8 мянган төгрөгийг Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга гэж буруу тайлагнасан.
- Мөнгөн гүйлгээний тайланг Сангийн сайдын 2017 оны "Маягт заавар батлах тухай" 361 дүгээр тушаалын дагуу ангилж тайлагнаагүй 31.2 мянган төгрөгийн зөрүүтэй тайлагнасан зэрэг алдааг залруулан тайлагнуулсан.

Аудитаар нийт 42,703.9 мянган төгрөгийн зөрчил² илэрснээс 1,174.4 мянган төгрөгийн 1 төлбөрийн акт тогтоож, 26,046.6 мянган төгрөгийн зөрчлийг давтан гаргахгүй байх 2 албан шаардлага хүргүүлж, 15,482.9 мянган төгрөгийн зөрчилд 3 зөвлөмж өгсөн.

5.1 Төлбөрийн акт

1. Үйл ажиллагааны бус зардалтай холбоотой асуудал

Тайлант онд торгууль, алданги болон хугацаа хэтэрсэн зээлийн хүүгийн зардал зэрэг үйл ажиллагааны бус 1,174.4 мянган төгрөгийн зардал гарсан байгаа нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.2.1 "зардал бууруулахад чиглэсэн арга хэмжээг энгийн ойлгомжтой, тууштай, өндөр сахилга баттайгаар зохион байгуулах" гэсэн заалтыг зөрчиж байна.

5.2 Албан шаардлага

1. Анхан шатны баримттай холбоотой асуудал

Тайлант онд 26,046.6 мянган төгрөгийн зарлагын гүйлгээ Цахим төлбөрийн баримтаар баталгаажуулахгүй нь Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.3.2 "бэрх, ажил, үйлчилгээг борлуулсан тухай бүр төлбөрийн баримтыг татвар төлөгчид олгоно", 17.6 "Албан татвар суутгаан төлөгч төлбөрийн баримтыг өөр дүнгээр олгосон, эсхүл төлбөрийн баримт олгохоос татгалзсан бол албан татвар төлөгч энэ татвар татварын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад, эсхүл харьяа татварын албанд нэн даруй мэдэгдэх үүрэгтэй" гэсэн заалттай тус тус нийцэхгүй, санхүүгийн тайлангнэлын эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

2. Үндсэн хөрөнгийн данстай холбоотой асуудал

Санхүүгийн тайланд бүртгэлгүй дөрвөн тээврийн хэрэгсэл Автотээврийн үндэсний төвд бүртгэлтэй байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6 "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах" гэсэн заалттай нийцэхгүй, санхүүгийн тайлангнэлын эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

¹ Тайлагнасан санхүүгийн тайлангийн үзүүлэлт, тайлагнасан байвал зохих үзүүлэлтийн хоорондын зөрүү. Мэдээллийг тусгахгүй орхиуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодог байдлыг буруу тайлбарласан (буруу ойлгосон), хайнгз хандсан (мартсан, тэмдэглээгүй орхисон).

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харилцах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Шатахууны тооцоотой холбоотой асуудал

Илрүүлэлт-1: Шатахууны зардлыг "Шатахууны тооцооны хуудас"-тай тулган шалгахад 14,832.9 мянган төгрөгөөр илүү тайлагнасан нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.2 "Төрийн өмчийн эд хөрөнгийн анхан шатны бүртгэл, тооллого, тайлан тэнцэл гаргах ажлын зохион байгуулж удирдах, төрийн өмчийн эд хөрөнгийн ашиглалтад хяналт тавьж, түүнийг үр ашгийг дээшлүүлэх арга хэмжээ авах" гэсэн заалтыг зөрчиж байна.

Өгсөн зөвлөмж: Шатахууны анхан шатны бүртгэл, тооллогыг үнэн зөв гаргах, санхүүгийн дотоод хяналтыг сайжруулах

2. Дотоод хяналттай холбоотой асуудал

Илрүүлэлт-2 Байгууллагын хөрөнгөд бүртгэлтэй тээврийн хэрэгсэл 650.0 мянган төгрөгийн хуримтлагдсан торгуулийн өр smartcar.mn сайтад төлөгдөөгүй төлөвтэй байгаа нь Төслийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.1 "Төслийн байгууллагын өдөр тутмын үйл ажиллагааг удирдах", санхүүгийн тайлагналын "эрх ба үүрэг" батлаж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Хөрөнгийн хяналтыг сайжруулах.

3. НБББББ-тэй холбоотой асуудал

Илрүүлэлт-3 Байгууллага 2018 онд боловсруулан мөрдөж буй НБББББ-т шинээр гарсан хууль, дүрэм, журамд нийцүүлэн өөрчлөлтийг тухай бүр хийгээгүй, 2023 оны 02 дугаар сарын 17-ны өдөр Зорчигч тээвэр гурав ОНӨААТҮГ-ын даргын "Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг шинэчлэн боловсруулах ажлын хэсэг байгуулах тухай" А/25 дугаар тушаалын дагуу үр дүнтэй ажил хийгээгүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйл "өрөнхий нягтлан бодогчийн эрх үүрэг" 20.2.2 "аж ахуйн нэгж, байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг боловсруулах, батлуулах, хэрэгжилтийг зохион байгуулах," гэж звасныг хэрэгжүүлээгүй.

Өгсөн зөвлөмж: НБББББ-т шинээр гарсан хууль, дүрэм, журамд нийцүүлэн өөрчлөлтийг хийж батлуулах

Дээрх албан шаардлага, зөвлөмжийн биелэлтийг Төрийн аудитын байгууллагад 2024 оны 08 дугаар сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

АУДИТЫН ТАЙЛАНГ БЭЛТГЭСЭН:

"МЭДЭЭЛЭЛ АУДИТ" ХХК-ийн

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

АУДИТОР

Д.ТОВУУДОРЖ

Д.ТУЯА

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

6.1 Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Мөнгөн төгрөгөөр

Д.д	Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй оролцогдсон		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
		Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй оролцогдсон		Буруу тусган илэрхийлсэн		Загваруулсан		Загваруулаагүй		Зөвлөмж	
								Загваруулсан		Загваруулаагүй			
1	Урт хугацаат өр төлбөрөөс бөгөөд хугацаат өр төлбөр дансанд шилжүүлж бүртгээгүй	1	4,476,398.1			1	4,476,398.1	1	4,476,398.1				
2	Ногодол ашгийн өглөгийг дансны өглөг дансанд ангилал буруу тээлэгчээс	1	392,197.8			1	392,197.8	1	392,197.8				
3	ЗДТГ-т өгөх 2022 оны ногодол ашиг 492,197.8 мянган төгрөгийг нийтлэн бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулгад тээлэгчээс	1	492,197.8			1	492,197.8	1	492,197.8				
4	Мөнгөн гүйлгээний тайланд 31.2 мянган төгрөгийн ангилал буруу тээлэгчээс	1	31.2			1	31.2	1	31.2				
	Дүн	6	5,376,193.1			6	5,376,193.1	6	5,376,193.1				

Мөнгөн төгрөгөөр

6.2 Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

Д.д	Зөрчлийн товч утга	Үүнээс										Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
		Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Тайлант онд торгууль, алд анги болон хугацаа хэтэрсэн зээлийн хүүгийн зардал зэрэг үйл ажиллагааны бус 1,174.4 мянган төгрөгийн зардал гарсан.	1	1,174.4	1	1,174.4								
2	Шатахууны зардалыг "Шатахууны тооцооны хуудас"-тай тулган шалгахад 14,832.9 мянган төгрөгөөр илүү тайлагнасан.	1	14,832.9					1	14,832.9				
3	2023 онд 26,046.6 мянган төгрөгийн зарлагын гүйлгээ цөхм төлбөрийн баримтаар баталгаажавгүй.	1	26,046.6			1	26,046.6						
4	Санхүүгийн тайланд бүртгэлгүй дөрвөн тээврийн хэрэгсэл Автотээврийн үндэсний төнд бүртгэлтэй байна.	1	-			1	-						
5	2 тээврийн хэрэгслийн 650.0 мянган төгрөгийн хуримтлагдсан торгуулийн өр 2018 оны 12 сарын 31-ийн төлөвлөгөө сайтад төлөгдөөгүй төлөвтэй байна.	1	650.0					1	650.0				
6	2018 онд боловсруулан мөрдөж буй НБББББ-т шинээр гарсан хууль, дүрэм, журамд нийцүүлэн өөрчлөлтийг тусай бүр хийгээгүй.	1	-					1	-				
	Дүн	6	42,703.9	1	1,174.4	2	26,046.6	3	15,482.9				

/мянган төгрөгөөр/

6.3 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцийн аудитын асуудал

Д.д	Зөрчлийн товч үгс	Нийт зөрчил		Үүнээс						Амьтан төгрөгөөр		
				Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж				
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн			
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил												
1	Шилэн дансанд 5 мэдээллийг хугацаа хоцроож байрлуулсан.	1	1,241,525.4			1			1,241,525.4			
	Дүн	1	1,241,525.4			1			1,241,525.4			

милан төгрөгөөр



НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АКТ

2024 оны 03 сарын 15 өдөр

Дугаар 50/13525063

Улаанбаатар хот

НТАГ- 2024/59 / 118-СТА-048

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Зорчигч тээвэр гурав ОНӨААТҮГ-ын 2023 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тайлант онд торгууль, алданги болон хугацаа хэтэрсэн зээлийн хүүгийн зардал зэрэг үйл ажиллагааны бус 1,174,380.00 (нэг сая нэг зуун далан дөрвөн мянга гурван зуун ная) төгрөгийн зардал гарсан байгаа нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.2.1. "зардал бууруулахад чиглэсэн арга хэмжээг энгийн ойлгомжтой, тууштай, өндөр сахилга баттайгаар зохион байгуулах" гэж заасныг зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т "Шалгагддагч этгээд төсөө, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/35 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.3. "Төлбөрийн акт тогтооход дарваах нийтлэг үндэслэлийг харгалзана", 4.2.3.6. "Эрх бүхий этгээдээс тогтоосон норм, нормативыг хэтрүүлэн зарцуулсан" заалтад заасныг үндэслэн **ТОГТООХ** нь:

1. Зорчигч тээвэр гурав ОНӨААТҮГ нь 1,174,380.00 (нэг сая нэг зуун далан дөрвөн мянга гурван зуун ная) төгрөгийг Нийслэл дэх Төрийн аудитын газрын Төрийн сан банкин дахь НТАГ-хүү орлогын 100200000908 тоот дансанд төвлөрүүлэх;

2. Актын биелэлтийг 2024 оны 05 дугаар сарын 31-ний дотор Нийслэл дэх Төрийн аудитын газар-т ирүүлэхийг Зорчигч тээвэр гурав ОНӨААТҮГ-ын дарга О.Ганбаатар, ерөнхий нягтлан бодогч Б.Баярцэцэг нарт хариуцуулав.

ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН1:

МЭДЭЭЛЭЛ АУДИТ ХХК
ЗАХИРАЛ

САНХҮҮ-НИЙЦЛИЙН АУДИТЫН
ХЭЛТСИЙН ДАРГА,

АУДИТЫН МЕНЕЖЕР

ХЯНАСАН

Д.ТОВУУДОРЖ

Х.ТҮВШИНБАЯР

Д.ОТГОНБАЯР

1 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо, Г.Амарын гудамж, Соёлын төв өргөө, Г корпус, 4 давхар

002051037



НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2024 оны 05 сарын 15 өдөр

Дугаар 168 / 17525063

Улаанбаатар хот

47785-2024/59/144-СТН-044

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Зорчигч тээвэр гурав ОНӨААТҮГ-ын 2023 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэртээ. Үүнд:

Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст тайлант хугацаанд цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий нийт оруулбал зохих 149 мэдээллээс 5 мэдээлэл буюу 1,241,525,405.00 (нэг тэрбум хоёр зуун дөчин нэг сая таван зуун хорин таван мянга дөрвөн зуун тав) төгрөгийн мэдээллийг хугацаа хоцроон байршуулсан байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1. "Энэ хуулийг хэрэгжүүлэхэд дараах зарчмыг баримтална", 4.1.1. "мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх", 4.1.2. "мэдээлэл ойлгомжтой, ач холбогдолтой байх", 4.1.3. "тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүрэгээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.10. "аудитаар илэрсэн алдаа, зөрчил, түүнийг арилгахаар өгсөн зөвлөмжийг хугацаанд нь хэрэгжүүлээгүй бол", 4.2.1.11 "хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" заалтад заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангаагүй зөрчлийг арилгаж, биелэлтийг 2024 оны 05 дугаар сарын 25-ны дотор Нийслэл дэх Төрийн аудитын газарт ирүүлэх;

2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Зорчигч тээвэр гурав ОНӨААТҮГ-ын дарга О.Ганбаатар, ерөнхий нягтлан бодогч Б.Баярцэцэг нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨНІ:

МЭДЭЭЛЭЛ АУДИТ ХХК-ИЙН
ЗАХИРАЛ

Д.ТОВУУДОРЖ

ХЯНАСАН:

САНХҮҮ-НИЙЦЛИЙН АУДИТЫН
ХЭЛТӨЙН ДАРГА

Х.ТҮВШИНБАЯР

АУДИТЫН МЕНЕЖЕР

Д.ОТГОНБАЯР



НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2024 оны 05 сарын 15 өдөр

Дугаар 64/13620063

Улаанбаатар хот

НТМГ-2001/59/11А-СФ-0111

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Зорчигч тээвэр гурав ОНӨААТҮГ-ын 2023 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тайлант онд 26,046,600.00 (хорин зургаан сая дөчин зургаан мянга зургаан зуу) төгрөгийн зарлагын гүйлгээ Цахим төлбөрийн баримтаар баталгаажуулж байна.

Энэ нь Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 17.3.2 "бараа, ажил, үйлчилгээг борлуулсан тухай бүр төлбөрийн баримтыг татвар төлөгчид олгоно", 17.6 "Албан татвар суутгаан төлөгч төлбөрийн баримтыг өөр дүнгээр олгосон, эсхүл төлбөрийн баримт олгохоос татгалзсан бол албан татвар төлөгч энэ талаар татварын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад, эсхүл харьяа татварын албанд нэн даруй мэдэгдэх үүрэгтэй" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүрэг биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.11, "хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" заалтад заасныг үндэслэн **ШААРДАХ** нь:

1. Анхан шатны баримтын бүрдэл дутуу бүртгээ хөтөлсөн зөрчлийг арилгаж, биелэлтийг 2024 оны 05 дугаар сарын 25-ны дотор Нийслэл дэх Төрийн аудитын газарт ирүүлэх.

2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Зорчигч тээвэр гурав ОНӨААТҮГ-ын дарга О.Ганбаатар, өрөнхий нягтлан бодогч Б.Баярцэцэг нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

МЭДЭЭЛЭЛ АУДИТ ХХК-ИЙН
ЗАХИРАЛ

Д.ТОВУУДОРЖ

САНХҮҮ-НИЙЦЛИЙН АУДИТЫН
ХЭЛТСИЙН ДАРГА

ХЯНАСАН:

Х.ТҮВШИНБАЯР

АУДИТЫН МЕНЕЖЕР

Д.ОТГОНБАЯР



НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2024 оны 03 сарын 15 өдөр

Дугаар А0/135250-63

Улаанбаатар хот

91587-8024/59 938-CTH-DHA

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Зорчигч тээвэр гурав ОНӨААТҮГ-ын 2023 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Санхүүгийн тайланд бүртгэлгүй дөрвөн тээврийн хэрэгсэл Автотээврийн үндэсний төвд бүртгэлтэй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6. "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, батлан нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах" гэж заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүтээсэн албан үүрэг биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талвар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.11. "хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" заалтад заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1.Тээврийн хэрэгслийн бүртгэлтэй холбоотой зөрчлийг арилгаж, биелэлтийг 2024 оны 05 дугаар сарын 25-ны дотор Нийслэл дэх Төрийн аудитын газарт ирүүлэх;

2.Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Зорчигч тээвэр гурав ОНӨААТҮГ-ын дарга О.Ганбаатар, ерөнхий нягтлан бодогч Б.Баярцэцэг нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨНІ:

МЭДЭЭЛЭЛ АУДИТ ХХК-ИЙН
ЗАХИРАЛ

Д.ТОВУУДОРЖ

ХЯНАГАН:

САНХҮҮ-НИЙЦЛИЙН АУДИТЫН
ХЭЛТСИЙН ДАРГА

Х.ТҮВШИНБАЯР

АУДИТЫН МЕНЕЖЕР

Д.ОТГОНБАЯР